

Хяналт шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/539 дүгээр захирамжаар батлагдсан Орон сууцны бодлогын газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/03 дугаар албан шаардлагын хүрээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод, хяналт шалгалт зохион байгуулах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд бүрэн судалж, үндэслэл бүхий хариу өгч, зөрчил гаргахгүй ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, сар тутам тайлагнахыг хэлтсүүдийн дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНХҮҮ

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын
2025 оны ... дугаар сарын ... –ны өдрийн ...
дугаар тушаалын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ 02/03 ДУГААР АЛБАН ШААРДЛАГЫН
ХҮРЭЭНД ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ,ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үүрэг даалгавар	Хийж хэрэгжүүлэх ажил	Хугацаа
1	2	3	4
1.	Өргөдөл, гомдолд дурдсан асуудал, бүрийг бүрэн судалж, хуулиар тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу өгч, эцэслэн шийдвэрлэх.Цаашид тухайн төрлийн зөрчил, дутагдлыг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Иргэдээс 2024 онд байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлуудыг судлах	2025.01.24- 2025.01.30
		Өргөдөл, гомдлыг хуулийн үндэслэлтэй, шуурхай шийдвэрлэж хариуг бүрэн өгсөн эсэхийг хянах	
		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
		Өргөдөл, гомдлыг хугацаанд нь үндэслэл бүхий шийдвэрлэн ажиллах талаар албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах	
		Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 02/03 дугаар албан шаардлагын хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дотоод хяналт, шалгалт хийсэн ажлын тайланг танилцуулах	2025.02.05

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.БОЛОРТУЯА

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯЛАГ